



ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2022.10.03 № 03/6773
танай _____-ны № _____-т

Санал авах тухай

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас 2023 онд Монгол Улсад хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжлийн төлөөх шинжлэх ухаан, технологийн судалгааны төсөл" /SATREPS/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай судалгааны төслийн саналыг нэгтгэн хүргүүлэхээр төлөвлөж байгаа тул эрхлэх асуудлын хүрээнд доорх шаардлагуудыг хангасан төслийн саналаа боловсруулан 10 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.


Судалгааны төсөлд тавигдах шаардлагууд:

1. Японы талын судалгааны байгууллага эсхүл их сургуультай хамтарсан байх;
2. Тогтвортой хөгжлийн төлөөх шинжлэх ухаан, технологийн судалгааны төслийн хүрээнд хамтран ажиллах салбаруудтай уялдсан байх;
3. ЖАЙКА-гаас ирүүлсэн төсөл боловсруулах загварын дагуу төслийн хүсэлтийг боловсруулсан байх.

Тогтвортой хөгжлийн төлөөх шинжлэх ухаан, технологийн судалгааны төслийн танилцуулга болон төслийн санал боловсруулах маягыг Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын мэргэжилтэн Т.Баярмаатай bayarmaa.t@mof.gov.mn хаягаар холбогдон авах боломжтой болно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨСВИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТМЙН
ГАЗРЫН ДАРГА

М.САНЖААДОРЖ



Т. Энхсүхбаатар
Борлоо-г

Төсвийн
санал
хүргүүлэв

[Handwritten signature]
x/s.22

9766014830